

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2023/66/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2023 он

Дархан Уул аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр
Утас: Цахим хаяг: munkhbayrsh@audit.gov.mn
Аудитын менежер: У.Батсүрэн
Утас: Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: Цахим хаяг: battsetsgs@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Си Эс Ай Аудит ХХК
Захирал: М.Сэвжидмаа
Утас: 70001981
Цахим хаяг: sevjidmaa@csiaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
3.1 Албан шаардлага	10
3.2 Зөвлөмж	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.	11

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ШГС	Шарын гол



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.25 № 108

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сум хөгжүүлэх сан нь Шарын гол сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 16 дугаар тогтоолоор Хоршоо хөгжүүлэх сан болж шинэчлэгдсэнтэй холбогдуулан хоршоо, аж ахуй нэгж, байгууллагуудад олгох зээлийн хэмжээ нэмэгдэн 30,000.0 мянган төгрөг болсон байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь бодлогын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 4 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, 98 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

008030230

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	417,687,336.37	425,562,116.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	68,575,777.46	184,580,578.34
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	68,575,777.46	184,580,578.34
3121	Төгрөг	68,575,777.46	184,580,578.34
31211	Төрийн сангийн харилцах	68,575,777.46	184,580,578.34
33	АВЛАГА	349,111,558.91	240,981,538.47
334	Зээлийн хүүгийн авлага	5,814,598.51	5,204,126.98
335	Бусад авдага	343,296,960.4	235,777,411.49
3352	Хувь хүмүүсээс авах авлага	343,296,960.4	235,777,411.49
33300	Татаас, санхүүжилтийн авлага		
335	Бусад авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
392	Биет хөрөнгө		
393	Биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	417,687,336.37	425,562,116.81
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	649,129	1,951,661.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	649,129	1,951,661.9
413	Өглөг	649,129	1,951,661.9
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	649,129	1,951,661.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	417,038,207.37	423,610,454.91
51	Засгийн газрын хувь оролцоо	417,038,207.37	423,610,454.91
511	Засгийн газрын оруулсан капитал ЗГС орон нутаг		
51100	Өмч-Төрийн		
51200	Хуримтлагдсан үр дүн	417,038,207.37	423,610,454.91
51210	Өмнөх үеийн үр дүн	417,038,207.37	417,038,207.37
51220	Тайлант үеийн үр дүн		6,572,247.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	417,687,336.37	425,562,116.81

Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	10,791,061.05	7,209,047.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,791,061.05	7,209,047.54
120	Нийтлэг татварын бус орлого	10,791,061.05	7,209,047.54
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,791,061.05	7,209,047.54
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,791,061.05	7,209,047.54
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилт		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	894,900.00	636,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	894,900.00	636,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	894,900.00	636,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
210101	Үндсэн цалин		
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх		
210201	Тэтгэврийн даатгал		
210202	Тэтгэмжийн даатгал		
210203	ҮОМШӨ-ний даатгал		
210204	Ажилгүйдлийн даатгал		
210205	Эрүүл мэндийн даатгал		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал		
210402	Тээвэр шатахуун		136,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		136,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	894,900.00	500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	894,900.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	9,896,161.05	6,572,247.54
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН		
5	НИЙТ ҮР ДҮН	9,896,161.05	6,572,247.54

Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	156,979,662.00	146,641,600.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,669,293.73	146,641,600.88
120	Нийтлэг татварын бус орлого	6,669,293.73	146,641,600.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,669,293.73	146,641,600.88
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	6,669,293.73	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	150,310,368.27	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	150,310,368.27	
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс иргэж төлөгдөх	150,310,368.27	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,070,950.00	636,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,070,950.00	636,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,070,950.00	636,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210604	Урсгал засвар		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,070,950.00	636,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,070,950.00	136,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		400,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		100,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг		
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	155,908,712.00	146,004,800.88
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	136,000,000.00	30,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	136,000,000.00	30,000,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(136,000,000.00)	(30,000,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	19,908,712.00	116,004,800.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		68,575,777.46
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		184,580,578.34

Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант оны үеийн үр дүн цэвэр ашиг алдагдал				
2021 оны 12 дугаар сарын 31-ээрх үлдэгдэл			417,038,207.37	417,038,207.37
2022 оны 01 дүгээр сарын 01-ээрх үлдэгдэл			417,038,207.37	417,038,207.37
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн			6,572,247.54	6,572,247.54
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			423,610,454.91	423,610,454.91

Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	120,000,000.00	30,636,800.00	(30,636,800.00)	25.5
УРСГАЛ ЗАРДАЛ	5,000,000.00	636,800.00	(636,800.00)	12.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000.00	636,800.00	(636,800.00)	12.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил				
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл				
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				
Байрны түрээс				
Хангамж, бараа материалын зардал				
Бичиг хэрэг				
Тээвэр шатахуун		136,800.00	136,800.00	-100.0
Эд хогшил, урсгал засварын зардал				
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	500,000.00	(500,000.00)	10.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл	400,000.00	400,000.00	(400,000.00)	100.0
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,600,000.00	100,000.00	(100,000.00)	2.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ				
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	115,000,000.00	30,000,000.00	(30,000,000.00)	26.0
Эргэж төлөгдөх зээл	115,000,000.00	30,000,000.00	(30,000,000.00)	26.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	120,000,000.00	146,641,600.88	(26,641,600.88)	122.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	120,000,000.00	146,641,600.88	(26,641,600.88)	122.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000,000.00	146,641,600.88	(26,641,600.88)	122.2
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		68,575,777.46	(68,575,777.46)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		184,580,578.34	184,580,578.34	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСДЫН ТОО	3	3	0.00	100.0
Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	2	2	0.00	100.0
Үйлчлэх ажилтан				

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,194.4 мянган төгрөгийн алдаа илэрснээс, 2,057.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 136.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

Илрүүлэлт-1 : Зээлдэгчийн зээлийн хүү, алдангийн тооцооллыг буруу тооцоолсноос зээл төлөх дүн, зээлийн авлага дутуу тайлагнагдсан, үүнээс үүдэн зээл төлсөн иргэдийн зээл илүү төлсөн 2,057.6 мянган төгрөгөөс 1,951.7 мянган төгрөгийг өглөгийн дансанд бүртгэж бусад 105.9 мянган төгрөгийг 17 зээлдэгчийн зээл рүү хаасан зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн тооцооллыг дахин давтан шалгаж зээлдэгч болгоноор тооцоог баталгаажуулах. Зээлдэгчийн төлсөн мөнгийг өөр зээлдэгчийн зээлийн тооцоог хааж ёс зүйгүй үйлдэл гаргахгүй, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах. Албан шаардлага хүргүүлэх.

3.2 Зөвлөмж

Илрүүлэлт 1: Монгол банкны мэдээллийн санд зээлийг бүртгэх программын төлбөр тооцоог хийгээгүйгээс /2022 оны 7 сараас хойш программ хаагдсан/ зээлийн эргэн төлөлт хүү алданги, зээлийн мэдээллийн санд тайлан мэдээ бүртгэл байхгүй, мөн монгол банкны зээлийн мэдээллийн санд нэгтгэхтэй холбоотой дотоод журам батлаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалын хавсралт 3.1.3-д “Сангаас олгосон зээлийн бүртгэл, хяналт, нэгтгэлийн системийг бүрдүүлэн хөтлөх, холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд нэгтгэхтэй холбоотой дотоод журам батлах” 9.3-д “Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд тогтмол нийлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол банкны зээлийн мэдээллийн санд хууль тогтоомжийн дагуу бүртгэж тайлагнах, холбогдох дотоод журам батлах зөвлөмж хүргүүлэх.

Илрүүлэлт 2: Эдийн засгийн ангилал зөрүүлэн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрийн данснаас 136.8 мянган төгрөгийг шатахуун авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” Сангийн сайдын 2021 он 190 дүгээр тушаалын хавсралт “Эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зээлийн үйл ажиллагааны зардлыг уялдуулан батлуулж Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах зөвлөмж хүргүүлэх.

Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Зээлдэгчийн зээлийн хүү, алдангийн тооцооллыг буруу тооцоолсноос зээл төлөх дүн, зээлийн авлага дутуу тайлагнагдсан, үүнээс үүдэн зээл төлсөн иргэдийн зээл илүү төлсөн 2,057.6 мянган төгрөгөөс 1,951.7 мянган төгрөгийг өглөгийн дансанд бүртгэж бусад 105.9 мянган төгрөгийг 17 зээлдэгчийн зээл рүү хаасан байна.	1	2057.6			1	2057.6							
Монгол банкны мэдээллийн санд зээлийг бүртгэх программын төлбөр тооцоог хийгээгүйгээс 2022 оны 7 сараас хойш программ хаагдсанаас зээлийн эргэн төлөлт хүү алданги, зээлийн	1	-					1	-					

Шарын гол сумын Хоршоо хөгжүүлэх сан 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

мэдээллийн санд тайлан мэдээ бүртгэл байхгүй, мөн монгол банкны зээлийн мэдээллийн санд нэгтгэхтэй холбоотой дотоод журам батлаагүй байна.											
Эдийн засгийн ангилал зөрүүлэн бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөрийн данснаас 136.8 мянган төгрөгийг шатахуун авсан байна	1	136.8				1	136.8				
Дүн	3	2194.4			1	2057.6	2	136.8			

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
		-				-		
Дүн								
Нийт дүн	3	2194.4			1	2057.6	2	136.8